

Сонгуулийн хорооны  
хуралдааны дэг батлах тухай

Сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.8 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Сонгуулийн Ерөнхий Хорооноос ТОГТООХ нь:

- 1.“Сонгуулийн хорооны хуралдааны дэг”-ийг хавсралтаар баталсугай.
- 2.Сонгуулийн хорооны хуралдаанд энэхүү дэгийг баримталж ажиллахыг сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.
3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Сонгуулийн Ерөнхий Хорооны 2012 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн “Сонгуулийн хороодын хуралдааны үлгэрчилсэн дэг батлах тухай” 27 дугаар тогтоол, 2013 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн “Сонгуулийн хороодын хуралдааны үлгэрчилсэн дэг батлах тухай” 11 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ч.СОДНОМЦЭРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ц.БОЛДСАЙХАН

Сонгуулийн Ерөнхий Хорооны  
2016 оны ..... дугаар сарын .....-ны өдрийн  
.... дугаар тогтоолын хавсралт

## СОНГУУЛИЙН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭГ

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо /цаашид хороо гэх/-ны хуралдааны зохион байгуулалт, үйл ажиллагаанд энэхүү дэгийг баримтална.

1.2. Хуралдаан нь хууль дээдлэх, дэгийг чанд сахих, асуудлыг чөлөөтэй хэлэлцэх, цөөнхийн санаа бодлыг хүндэтгэх, асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэх зарчимд үндэслэн явагдана.

1.3. Хуралдаанд сонгуулийн байгууллагын нийт бүрэлдэхүүний гуравны хоёроос доошгүй нь оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно. Хуралдаан даргалагч ирцийг заавал зарлана.

1.4. Сонгуулийн хорооны хуралдаан нь нээлттэй ил тод байх бөгөөд хуралдааны ажиллагаа, шийдвэрийн талаар нийтэд ил тод мэдээлнэ.

1.5. Гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг удирдан зохион байгуулах төв комисс болон гадаад улсад байгаа сонгогчдын санал авах ажлыг зохион байгуулах салбар комисс нь энэхүү дэгд нийцүүлэн хуралдааныг зохион байгуулна.

### **Хоёр. Хуралдааны бэлтгэл хангах**

2.1. Хорооны дарга, нарийн бичгийн дарга хуралдаанаар хэлэлцэх асуудал, хуваарийг гаргаж, тухайн сонгуулийн хорооны ажиллах байрны мэдээллийн самбарт ил тавина.

2.2. Хуралдаанаар хэлэлцэх асуудал нь хуулийн хүрээнд бүрэн боловсрогдсон, зохих тооцоо судалгаанд үндэслэгдсэн, архивт хадгалах баримтын шаардлага хангасан байна.

2.3. Хорооны гишүүд хорооны бүрэн эрхэд хамаарах асуудлыг санаачлан хуралдаанаар хэлэлцүүлж болох бөгөөд уг асуудлыг санаачилсан гишүүнийг нь байхад хэлэлцэнэ.

2.4. Хорооны нарийн бичгийн дарга хуралдаанаар хэлэлцэх баримт бичгийн төслийг иж бүрдэл болгож, хуралдахаас өмнө Хорооны даргад танилцуулж, хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулна. Хуралдаанаар хэлэлцэх асуудлын дарааллыг тогтооно.

2.5. Хуралдаанаар хэлэлцүүлэх баримт бичгийн төслийн эцсийн хувилбарыг бүрдүүлэх, бэлтгэх, олшруулах, бүртгэх, тэмдэг дарах, тараах ажлыг нарийн бичгийн дарга зохион байгуулж, хяналт тавина.

2.6.Хуралдаанаар хэлэлцэх асуудлын төсөл, танилцуулгыг хуралдаанаас өмнө Хорооны гишүүдэд хүргэсэн байна.

2.7.Хуралдаанаар хэлэлцэх баримт бичгийг Хорооны гишүүн бүрт хувилж тараасан байна.

2.8.Хуралдааны зар, холбогдох баримт бичгийг Хорооны гишүүд хүлээн авч тухайн хуралдаанд оролцох боломжгүй бол шалтгаанаа Хорооны даргад бичгээр болон бусад хэлбэрээр урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.

2.9.Хорооны гишүүд хуралдаанаар хэлэлцэх асуудал, холбогдох баримт бичгийн төсөлтэй бүрэн танилцаж, санал дүгнэлтээ урьдчилан бэлтгэсэн байна.

2.10.Хорооны шийдвэрийн төсөлтэй холбогдуулан бусад мэргэжлийн байгууллага, хүмүүсийн саналыг урьдчилан авч болно.

### **Гурав. Хуралдаан хийх**

3.1.Сонгуулийн хорооны ажиллах байрны багтаамжийг харгалзан сонгуульд оролцож байгаа улс төрийн нам, эвсэл, хамтарсан намуудын сонгуулийн штабын ажилтан, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, ажиглагч, төрийн бус байгууллагын ажилтныг байлцуулж болно. Хуралдаанд оролцогчид хуралдааны дэгийг чанд сахих үүрэгтэй.

3.2.Хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг батална. Хуралдааныг хорооны дарга удирдан явуулна.

3.3.Хорооны даргын түр эзгүйд түүний даалгаснаар хорооны аль нэг гишүүн хуралдааныг даргална.

3.4.Сонгуулийн хороо нь сонгууль зохион байгуулахтай холбоотой бүрэн эрхийнхээ дагуу асуудлыг хуралдаанаар хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Сонгуулийн хороодын гаргасан шийдвэр нь тогтоол, зөвлөмж, албан бичгийн хэлбэртэй байна. Шийдвэрт хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарна.

3.5.Хорооны шийдвэрт тухайн хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурахаас татгалзах эрхгүй.

3.6.Тухайн өдрийн хуралдаан эхлэхэд ирцэд бүртгүүлсэн сонгуулийн хорооны ажилтан, албан тушаалтан хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдааныг орхисон, тасалсан тохиолдолд хуралдааны ирцэд тооцон, хэлэлцсэн асуудлаар татгалзсан санал гаргасанд тооцно.

3.7.Хуралдаан даргалагч дараах эрхтэй:

3.7.1.Хуралдааны дэгийн биелэлтэд хяналт тавьж, хуралдаанд оролцогчдоос түүнийг биелүүлэхийг шаардах;

3.7.2.Хорооны гишүүд асуулт асуух, үг хэлэх, санал шүүмжлэл гаргахад зөвшөөрөл олгох;

3.7.3.Хэлэлцсэн асуудлаар санал хураалгаж, дүнг мэдээлж, эцсийн шийдвэрийг сонсгон батлуулах;

3.8.Хуралдааны тэмдэглэлийг Хорооны нарийн бичгийн дарга хөтөлнө. Хуралдаанд нарийн бичгийн дарга хүндэтгэн үзэх шалтгаанаар оролцох боломжгүй бол тэмдэглэлийг хуралдаан даргалагчийн даалгаснаар аль нэг ажилтан хөтөлнө.

3.9.Хуралдааныг завсарлагатай хийж болох бөгөөд завсарлах хугацаа 1 цагаас илүүгүй байна.

3.10.Шаардлагатай гэж үзвэл хэлэлцэх асуудлын онцлогийг харгалзан хуралдаанд бусад байгууллагын удирдлага, холбогдох бусад хүмүүсийг оролцуулж болно. Хуралдаан даргалагчийн зөвшөөрөлтэйгээр оролцогч үг хэлж болно.

3.11.Хуралдааны явцад дараах журмыг баримтална.

3.11.1.хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөсөн асуудлын дарааллыг хуралдаан даргалагч танилцуулах ба хэлэлцэх асуудлыг батлуулах;

3.11.2.хуралдааны төлөвлөгөөнд ороогүй боловч нэн яаралтай эсвэл зайлшгүй шаардлагатай хэлэлцэх асуудал гарвал хуралдаан даргалагчийн санал оруулсанаар хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэх;

3.11.3.асуулт, хариулт дууссаны дараа гишүүд үг хэлэх хүсэлт гаргасан дарааллаар саналаа гаргах;

3.11.4.асуулт, хариулт, санал нь зөвхөн хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоотой, товч тодорхой, давтагдахгүй байх;

3.11.5.хуралдааны явцад гишүүд гадагш түр гарах бол хуралдаан даргалагчаас зөвшөөрөл авах;

3.11.6.хуралдаан даргалагч хэлэлцэж байгаа асуудлын талаар гарсан саналыг нэгтгэж, санал тус бүрийг шийдвэрлүүлэх;

3.11.7.хорооны гишүүд зөвшөөрсөн эсвэл татгалзсан тухай саналын аль нэгийг заавал өгөх үүрэг хүлээнэ.

3.12.Хуралдаанд асуудал оруулж байгаа хүний илтгэл, сонсголыг сонссоны дараа Хорооны гишүүн асуулт тавина.

3.13.Хуралдаан даргалагчийн зөвшөөрөлтэйгээр хуралдаанд оролцогчийн үг хэлэх хугацаа 5 минутаас хэтрэхгүй байна.

3.14.Хэд хэдэн асуудлаар санал хураах тохиолдолд дэс дарааллыг хуралдаан даргалагч тогтооно.

3.15.Хорооны гишүүд саналаа илээр өгнө.

3.16.Хуралдааны хугацааг сунгаж болох бөгөөд уг асуудлыг санал хураалтаар шийдвэрлэнэ.

3.17.Хуралдаан дууссаны дараа өөрсдийн ажилласан, санал дүгнэлт хийсэн баримт бичгийн төслийг Хорооны гишүүд тэмдэглэл хөтлөгчид хүлээлгэн өгч болно.

### ***Дөрөв. Хуралдааныг баримтжуулах, шийдвэрийг ёсчлон гаргах***

4.1.Хуралдааныг баримтжуулах ажлыг Хорооны нарийн бичгийн дарга хариуцана.

4.2.Хуралдаанаар хэлэлцсэнээс хойш ажлын журмаар дахин боловсруулахаас бусад асуудлаар гарах шийдвэрийг нэн даруй ёсчлон гаргана.

4.3.Шийдвэрийг албан хуудсанд бичигдсэний дараа алдааг хянан эхний хуудасны ар талын зүүн доод хэсэгт боловсруулсан, хянасан тухай гарын үсэг зурж, Хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарж ёсчлоно.

4.4.Сонгуулийн хороо нь хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл, гарын үсэг зурсан шийдвэрийн эх хувийг зохих журмын дагуу архивт шилжүүлнэ.

4.5.Хуралдаанаар шийдвэрлэсэн асуудалд зарчмын шинжтэй өөрчлөлт оруулах бол заавал хуралдаанаар дахин хэлэлцүүлж шийдвэрлэнэ.

### **Тав. Хориглох зүйл**

5.1.Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд ирэхгүй байх, таслах, хуралдааныг орхих, хуралдааны тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзахыг тус тус хориглоно.

5.2.Сонгуулийн хорооны бүрэлдэхүүн болон хуралдаанд оролцогч бусад этгээд хуралдаан даргалагчийн зөвшөөрөлгүйгээр хуралдааны танхимд орж гарах, гар утсаар ярихыг хориглоно.

5.3.Энэ дэгийн 3.1-д заасны дагуу сонгуулийн хорооны хуралдааныг ажиглаж байгаа этгээд нь тухайн сонгуулийн хорооны бүрэн эрхийн асуудалд оролцох, хуралдаан даргалагчийн зөвшөөрөлгүйгээр үг хэлэх зэргээр хуралдааны хэвийн үйл ажиллагаанд саад учруулахыг хориглоно.

### **Зургаа. Хариуцлага**

6.1.Сонгуулийн тухай хууль тогтоомж болон энэ дэгд заасныг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---